Golomt Capital®

# Дотоодын зах зээлийн долоо хоногийн тойм

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ 2022.03.14

Анхаарлын төвд

## Индексийн өдрийн өөрчлөлт




| МХБ ИНДЕКС | 7 хоног | 1 сар | 1 жил |
|---|---|---|---|
| ТОП 20 | -5.79% | -11.2% | 9.4% |
| MSE A | -3.51% | -7.6% | 40.6% |
| MSE B | -3.01% | -2.7% | 12.6% |

| | Дүн (сая.төг) | Өөрчлөлт % |
|---|---|---|
| Зах зээлийн үнэлгээ | 5,399,117.0 | -3.3% |
| Арилжигдсан дүн | 2,055.5 | NA% |

| ИХ АРИЛЖААЛАГДСАН | Хаалтын ханш | Үнийн дүн |
|---|---|---|
| АПУ | 1,608 | 265,120,535 |
| Монгол Шевро | 2,560 | 250,009,310 |
| Ард Санхүүгийн Нэгдэл | 5,395 | 140,626,545 |
| Мандал Даатгал | 98.44 | 79,452,141 |
| Түмэн Шувуут | 558.84 | 61,326,453 |

| ӨНДӨР ӨСӨЛТТЭЙ | Хаалтын ханш | Өөрчлөлт % |
|---|---|---|
| Булган Ундрага | 117,900 | 17.90% |
| Люкс Занаду Групп | 1,035 | 15.00% |
| Хүнну Менежмент | 1,296 | 15.00% |
| Стандарт Проперти Групп | 62 | 14.71% |
| Могойн Гол | 10,000 | 11.11% |

## АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ | 2022/03/07-03/11

- Тайлант долоо хоногт МХБ-ийн арилжаагаар нийт 77 төрлийн 2.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 3,159,276 үнэт цаасны арилжаа хийгдлээ.
- Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5,399 тэрбум төгрөг болсон бол ТОП-20 индекс 36,982 нэгж болж өнгөрсөн долоо хоногоос 5.24%-иар унасан байна. Түүнчлэн MSE A индекс 13,897 нэгжид хүрч 3.51%-иар, MSE B индекс 12,017 нэгжид хүрч 3.01 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Хамгийн өндөр өсөлтийг Булган Ундрага (BUN) 17.90%, Люкс Занаду Групп (BAZ) 15.00%, Хүнну Менежмент (HBZ) 15.00% -иар тус тус үзүүллээ.
- Хамгийн их уналтыг Э-Транс Ложистикс (ETR) – 25.03%, Монгео (MOG) -14.63%, Аайтүүлс (ITLS) -12.08%-иар тус тус үзүүллээ.

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

**Инвескор ББСБ ХК-ийн цэвэр ашиг 68 хувиар өсөж 19.1 тэрбум төгрөгт хүрлээ**

*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

Монголын Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй Инвескор ББСБ ХК 2021 онд 19.1 орчим тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаа тайлагналаа. Энэ нь 2020 оноос 68.4 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Хүүгийн бус цэвэр орлого 8.8 тэрбум төгрөгт хүрсэн нь цэвэр ашиг өсөхөд голлох нөлөө үзүүлжээ. Тайлант хугацаанд тус компанийн үйл ажиллагааны орлого 37.1 тэрбум төгрөг хүрч, өмнөх оноос 62.7 хувиар өссөн дүнтэй байна. 2021 онд зээлийн багц нь 173.1 тэрбум төгрөг, харин харилцагчдын тоо нь 79.9 мянга хүрчээ. Зээлийн багцад эзлэх чанаргүй зээл өмнөх оноос 0.3 нэгж пунктээр буурч, 2.7 хувь болсон байна. Зээлийн багцын 40 хувийг бизнесийн зээл 30 хувийг автомашин, 19 хувийг дижитал, 11 хувийг хэрэглээний зээл бүрдүүлсэн аж. Сүүлийн 1 жилийн хугацаанд 36.5 хувиар нэмэгдэж, IPO хийснээс хойш 145 хувийн өсөлт үзүүлсэн байна.

**МХБ-д бүртгэлтэй компаниудад БОНЗ-ын тайлагналын стандартыг нэвтрүүлэх төслийг FC4S онцоллоо**

*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

СЗХ, МХБ, ТоС Холбоо, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP), Тогтвортой байдлын санхүүгийн төвүүдийн сүлжээ (FC4S), Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) нар **Монголын хөрөнгийн зах зээлд ESG буюу байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайлагналын стандартыг нэвтрүүлэх** төслийг хэрэгжүүлж байгаа билээ. FC4S-ээс 4 дэх удаа гаргаж буй Улс орнуудын тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэх үр дүнтэй үйл ажиллагааны талаарх үнэлгээний тайланд энэхүү төслийг онцолж, сайн туршлагаар шалгаруулсан байна.

| Их уналттай | Хаалтын ханш | Өөрчлөлт % |
|---|---|---|
| Э-Транс Ложистикс | 83.22 | -25.03% |
| Монгео | 7,700 | -14.63% |
| Айтүүлс | 84.57 | -12.08% |
| Монгол Алт | 13,200 | -12.00% |
| Их Барилга | 1,550 | -11.43% |

| ӨНДӨР ҮНЭЛГЭЭТЭЙ ТОП-5 | Хаалтын ханш | Үнэлгээ, тэрбум. Төг |
|---|---|---|
| АПУ | 1,608 | **1,709.3** |
| Тавантолгой | 6,805 | **358.4** |
| МИК | 15,500 | **321.0** |
| Инвескор ББСБ ХК | 4,130 | **296.2** |
| Эрдэнэ Ресурс Девелопмент | 857 | **250.0** |

| МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД | |
|---|---|
| Инфляцын түвшин | 14.6% |
| Бодлогын хүү | 6.5% |
| Хадгаламжийн дундаж хүү (төгрөг) | 7.3% |
| Хадгаламжийн дундаж хүү (ам.доллар) | 2.1% |
| Зээлийн дундаж хүү (төгрөг) | 12.2% |
| Зээлийн дундаж хүү (ам.доллар) | 9.0% |

## ХАРИЛЦАГЧИЙН БОЛОВСРОЛД: **ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?**

Худалдааны тэнцэл гэдэг нь тухайн улсын импорт экспортын тухайн хугацаанд бүртгэгдсэн зөрүү юм. Худалдааны илүүдэл нь тухайн улсын экспортын нийт дүн импортын үнээс өндөр байх явдал юм. Энэ нь худалдан авалтаас илүү борлуулалт их байсан гэсэн үг юм. Худалдааны алдагдал гэдэг нь бүх импортын үнэ экспортын үнээс давсан тохиолдолд юм. Худалдан авалт нь борлуулалтаас илүү их байсан гэсэн үг юм. Худалдааны тэнцэлд үндэсний болон гадаадын бүтээгдэхүүний талаархи хүн амын хэрэглээний сонголт, импортын бүтээгдэхүүний хэрэглэгчдэд борлуулах үнэ, гадаад худалдааны талаар төрөөс баримтлах бодлого зэрэг нөлөөлдөг байна.

## ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЭЭЛЭЛ

### Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2022 оны эхний 2 сарын байдлаар 142.5 сая ам.долларын ашигтай гарлаа

*Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар*

Хил гааль дэх гацаа үргэлжилсэн оны эхний хоёр сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа. Тодруулбал, гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны мөн үеэс бага зэрэг буурч, 2.2 тэрбум ам.доллар болжээ. Харин 1.2 тэрбум ам.долларын бараа, бүтээгдэхүүн экспортолсноор гадаад худалдааны тэнцэл 142.5 сая ам.долларын ашигтай гарсан байна. Экспорт 2021 оны мөн үеэс 11.5 хувиар буурсан ч 1 сараас өссөн байна. 1 дүгээр сард эрдсийн экспорт буурснаар гадаад худалдаа алдагдалтай гарсан юм. Харин 2022 оны эхний 2 сарын байдлаар экспортын барааны 72 хувийг эрдэс бүтээгдэхүүн эзэлж байна. Тайлант хугацаанд 849.9 сая ам.долларын эрдэс бүтээгдэхүүн экспортолсон нь 2021 оны мөн үеэс 28 хувиар буурсан дүн болж байна.

### Газрын тос дамжуулах хоолойн санхүүжилтийг нүүрсний урьдчилгаа борлуулалтаар шийдвэрлэнэ

*Эх сурвалж: Mongolian Mining Corporation*

Засгийн газрын 2022 оны 3 сарын 2-ны өдрийн ээлжит хуралдаанаар Газрын тос дамжуулах хоолой барихад шаардагдах хөрөнгө оруулалтын гэрээнд заасан мөнгөн дүн болох **397 сая ам.долларыг** нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхийг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгалаа. Түүнчлэн цар тахлын үед экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хилийн Гашуунсухайт боомтод 66 га газарт автомат удирдлага бүхий жолоочгүй чингэлэг тээврийн терминал байгуулах, түүний зориулалтаар газар ашиглахыг зөвшөөрлөө.

### Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлэв

*Эх сурвалж: Засгийн газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах газар*

Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт нь Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян өртөөнөөс Ханги боомт хүртэл 226 километр үргэлжилж БНХАУ-ын Мандал боомттой холбогдох юм. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор Ерөө өртөөнөөс БНХАУ-ын Бугат өртөө хүртэлх тээврийн зайг 1,722 км-ээс 1,404 км буюу 306 км-ээр дөт болгож, улмаар төмрийн хүдрийн тээвэрлэлтийн өртгийг 4-8 ам.доллароор бууруулахаар тооцоолжээ. Түүнчлэн экспорт, импорт өсөх, олон улсын төмөр замын шинэ гарц үүсэх, 1,600 гаруй ажлын байр бий болох боломж бүрдэх юм.

# АРИЛЖААНЫ БАНКУУДЫН 2021 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Балансын үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр | Хаан | ХХБ | Голомт | Төрийн | Хас | Капитрон | Транс | Чингис Хаан | Богд | Үндэсний хөрөнгө оруулалт | Ариг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 4,549.1 | 2,252.6 | 2,378.4 | 817.6 | 462.7 | 382.8 | 131.4 | 0.5 | 123.2 | 1.7 | 1.1 |
| Зээл (цэвэр дүнгээр) | 6,708.3 | 4,531.3 | 3,261.5 | 2,250.5 | 1,787.5 | 626.4 | 423.6 | 192.7 | 146.6 | 7.0 | 16.7 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **13,572.3** | **9,575.6** | **7,900.5** | **3,799.3** | **3,475** | **1284.1** | **713.2** | **301.4** | **327.1** | **102.3** | **102.3** |
| Харилцах | 2,930.0 | 1,765.2 | 1,764.3 | 658.3 | 461.4 | 189.8 | 58.2 | 167.9 | 26.9 | 63.8 | 3.3 |
| Хадгаламж | 7,038.1 | 3,868.5 | 3,570.8 | 2,187.6 | 1,790,7 | 554.9 | 259 | 57.6 | 95.7 | 69.5 | 31.1 |
| **Өр төлбөрийн дүн** | **12,168.9** | **8,506.4** | **7,304.5** | **3,405.8** | **3,106.7** | **1150.1** | **540.4** | **293.5** | **225.5** | **169.6** | **66.5** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 172.1 | 323.8 | 194.7 | 178.0 | 100.0 | 100.0 | 146.5 | 42.7 | 81.8 | 35.1 | 50.0 |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | 1,018.1 | 612.4 | 191.5 | 172.6 | 202.3 | 24.6 | 26.2 | -35.6 | 20.5 | (106.7) | (14.5) |
| **Өөрийн хөрөнгийн дүн** | **1,403.5** | **1,069.2** | **596.0** | **393.5** | **368.0** | **133.9** | **172.8** | **5.7** | **101.6** | **(67.4)** | **37.7** |
| **Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | **13,572.3** | **9,575.6** | **7,900.5** | **3,799.3** | **3,475** | **1284.1** | **713.2** | **301.4** | **327.1** | **102.3** | **102.3** |
| *Чанаргүй зээлийн хувь* | *5.1%* | *13.8%* | *7.6%* | *9.5%* | *4.4%* | *9.2%* | *2.8%* | *24.2%* | *3.6%* | - | - |
| **Орлогын үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр** | | | | | | | | | | | |
| Хүүгийн орлого | 1,182.3 | 576.0 | 576.1 | 372.6 | 327.5 | 100.4 | 50.7 | 22.7 | 25.9 | 9.7 | 6.4 |
| Хүүгийн зардал | 569.5 | 403.0 | 330.5 | 190.1 | 177.2 | 61.6 | 24.9 | 5.2 | 10.7 | 2.9 | 2.6 |
| **Хүүгийн цэвэр орлого** | **612.8** | **173.0** | **245.6** | **182.5** | **150.3** | **38.7** | **25.8** | **17.5** | **15.2** | **6.8** | **3.8** |
| Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого | 541.7 | 157.2 | 208.8 | 151.1 | 149.9 | 14.0 | 25.2 | 9.1 | 14.3 | (-32.6) | (5.1) |
| Бусад орлого | 290.6 | 213.9 | 98.3 | 38.0 | 43.8 | 21.8 | 4.3 | 0.8 | 9.4 | 90.4 | 2.8 |
| Бусад зардал | 445.8 | 281.3 | 273.9 | 123.5 | 103.2 | 27.4 | 16.2 | 9.7 | 12.2 | 51.1 | 0.1 |
| **Татварын дараах ашиг, алдагдал** | **291.5** | **89.7** | **22.1** | **51.5** | **62.2** | **7.2** | **10.6** | **0.08** | **10.2** | **6.7** | **(-3.6)** |
| **Шалгуур харьцаа үзүүлэлтүүд** | | | | | | | | | | | |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа >9% | 15.60% | 15.10% | 12.98% | 15.68% | 17.40% | 14.69% | 32.0% | 0.7% | 49.58% | -42.50% | 39.51% |
| Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа>12% | 15.60% | 15.10% | 13.28% | 15.68% | 17.40% | 14.69% | 32.0% | 0.7% | 49.58% | -42.50% | 39.51% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт >20% | 46.87% | 40.57% | 41.30% | 31.72% | 44.30% | 37.70% | 32.9% | -7.6% | 45.19% | 1.00% | 64.49% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) <+-15% | -1.87% | -10.47% | 11.98% | 9.32% | -1.10% | -8.48% | -2.4% | -211.4% | 5.65% | 72.00% | 11.51% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа <+-30% | -2.16% | -15.34% | 15.11% | 10.66% | -2.20% | -18.13% | -4.8% | -310.5% | 6.13% | 80.30% | 11.83% |

*Эх сурвалж: Арилжааны банкуудын албан ёсны вебсайт*

# МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн, тэрбум төгрөгөөр**




| Бодит сектор (их наяд төгрөг) | 2021Q4 | 2021Q4 | Өөрчлөлт, дүнгээр | Өөрчлөлт, хувиар |
|---|---|---|---|---|
| **Нэрлэсэн ДНБ** | 37.5 | 43.0 | 5.5 | 14.9% |
| **Бодит ДНБ, 2015 зэрэгцүүлэх үнээр** | 26.7 | 27.0 | 0.3 | 1.4% |
| **Бодит ДНБ өсөлт** | -4.6% | 1.4% | 6.0% | - |
| **Ажилгүйдлийн түвшин** | 6.6% | 8.8% | 2.2% | - |
| **Инфляцийн түвшин** | 2.3% | 13.4% | 11.1% | - |
| **Гадаад сектор (сая ам.доллар)** | | | | |
| **Гадаад худалдааны эргэлт** | 12,875.2 | 16,095.8 | 3,224 | 25.0% |
| **Экспортын хэмжээ** | 7,576.3 | 9,247.1 | 1,670.8 | 24.9% |
| **Импортын хэмжээ** | 5,298.9 | 6,848.6 | 1,549.5 | 30.5% |
| **Гадаад худалдааны тэнцэл** | 2,277.4 | 2,398.5 | 121.10 | 5.3% |
| **Төсвийн сектор (их наяд төгрөг)*** | | | | |
| Тэнцвэржүүлсэн орлого | 6.7 | 9.7 | 2.3 | 44.2% |
| Тэнцвэржүүлсэн зарлага | 9.4 | 10.9 | 1.5 | 15.9% |
| Тэнцвэржүүлсэн тэнцэл | (2.7) | (1.2) | 1.7 | -53.3% |
| **Мөнгөний сектор (их наяд төгрөг)** | | | | |
| Мөнгөний нийлүүлэлт | 24.2 | 27.9 | 3.7 | 15.0% |
| Нийт хадгаламж | 18.0 | 19.0 | 1.0 | 5.4% |
| Нийт харилцах | 5.4 | 8.0 | 2.6 | 47.5% |
| Нийт зээлийн үлдэгдэл | 17.0 | 20.7 | 3.7 | 21.3% |
| Хугацаа хэтэрсэн зээл | 1.3 | 0.9 | -0.4 | -26.3% |
| Чанаргүй зээл | 2.0 | 2.1 | 0.1 | 3.5% |
| Чанаргүй зээлийн хувь | 11.8% | 10.0% | -1.8% | - |
| Бодлогын хүү | 8% | 6% | -2.0% | - |

*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Монголбанк, Сангийн Яам*

*Төсвийн секторын үзүүлэлтүүдийг 2021 оны 3 дугаар улирал
*Бодит сектор, Мөнгөний сектор болон Гадаад секторын үзүүлэлтүүдийг 2021 оны 4 дүгээр улирлын байдлаарх тоон үзүүлэлтүүдэд тулгуурлан гаргалаа.

# ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Симбол | AIC | AARD | NEH | BODI | GOV | LEND | MNDL | MFC | SUU | TTL | TUM |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Компанийн нэр** | **Ард Даатгал** | **Ард Санхүүгийн Нэгдэл** | **Дархан Нэхий** | **Бодь Даатгал** | **Говь** | **ЛендМН ББСБ** | **Мах импекс** | **Монос Хүнс** | **Сүү** | **Таван Толгой** | **Тумэн Шувуут** |
| **Салбар** | Санхүү | Санхүү | Хөнгөн үйлдвэрлэл | Санхүү | Хүнсний үйлдвэрлэл | Санхүү | Хүнсний үйлдвэрлэл | Хүнсний үйлдвэрлэл | Хүнсний үйлдвэрлэл | Уул уурхай | Хөдөө аж ахуй |
| **Хаалтын ханш** | 906.59 | 5,395 | 24.49 | 126 | 266.3 | 38.04 | 3,604 | 112.08 | 530 | 6,805 | 558.84 |
| **САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (тэрбум төгрөг)** | | | | | | | | | | | |
| Хөрөнгө | 34 | 332.6 | 77.4 | 46.4 | 299.9 | 39.3 | 29.2 | 23 | 84.5 | 154.7 | 47.5 |
| Өр төлбөр | 15.7 | 22.7 | 21.5 | 31.7 | 270.7 | 19.5 | 24.2 | 5.9 | 51.5 | 94.4 | 17.4 |
| Эздийн өмч | 18.3 | 263.3 | 55.9 | 14.8 | 29.1 | 19.8 | 5.01 | 14.9 | 33 | 60.3 | 30.1 |
| Борлуулалтын орлого | 15.8 | 22.2 | 23.4 | 17.1 | 144.3 | 12.5 | 49.2 | 18.8 | 100.4 | 179.3 | 35.9 |
| Цэвэр ашиг | 7.1 | 1.3 | 3.6 | 2.3 | -38 | 4 | 1.4 | 2 | 9.4 | 15.1 | 6.9 |
| **ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД** | | | | | | | | | | | |
| Эргэлтийн харьцаа | 2 | 1.2 | 1.7 | 1.4 | 0.5 | 1.9 | 1.1 | 1.7 | 0.8 | 1.5 | 1.2 |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар | 2 | 1.2 | 1 | 1.4 | 0.5 | 1.9 | 0.6 | 0.7 | 0.5 | 1.1 | 0.8 |
| Өр ба хөрөнгийн харьцаа | 46% | 7% | 28% | 68% | 90% | 50% | 83% | 26% | 61% | 61% | 37% |
| Өр ба өмчийн харьцаа | 86% | 9% | 38% | 214% | 930% | 98% | 483% | 40% | 156% | 157% | 58% |
| Хөрөнгийн өгөөж | 21% | 0% | 5% | 5% | -13% | 10% | 5% | 9% | 11% | 10% | 15% |
| Эздийн өмчийн өгөөж | 39% | 0% | 6% | 16% | -130% | 20% | 28% | 14% | 29% | 25% | 23% |
| Нийт ахиуц ашиг | 83% | 100% | 32% | 112% | 41% | 78% | 3% | 45% | 27% | 13% | 31% |
| Цэвэр ахиуц ашиг | 45% | 6% | 15% | 13% | -26% | 32% | 3% | 11% | 9% | 8% | 19% |
| **P/E*** | **3.2** | **115.7** | **7.4** | **12.7** | **-5.5** | **7.6** | **10.1** | **22.6** | **19.4** | **23.8** | **16.1** |
| **P/B*** | **1.2** | **0.6** | **0.5** | **2.0** | **7.1** | **1.5** | **2.7** | **3.1** | **5.5** | **5.9** | **3.5** |
| **P/S*** | **1.7** | **7.0** | **1.2** | **1.6** | **1.4** | **2.9** | **0.3** | **2.4** | **1.8** | **2.0** | **3.1** |

*P/E, P/B, P/S харьцаа үзүүлэлтийг тооцоход:

- Нийт компаниудын санхүүгийн үзүүлэлтийг 2021 оны тайланд үндэслэж тооцсон болно.

# ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | Компанийн нэр | Цэвэр ашиг, сая төг. | Нийт ногдол ашиг, сая төг. | Ногдол ашиг тараалтын хувь | Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг, төг. | Ногдол ашиг тараах өдөр |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Түмэн шувуут | 6,940 | **2,082** | 30% | **10.41** | 07/01/2022 |
| 2 | ЛэндМН ББСБ | 3,891 | **1109** | 28% | **1.50** | 04/30/2022 |
| 3 | Улаанбаатар БҮК | 3,014 | **1,315** | 44% | **10.00** | 06/01/2022 |
| 4 | Тахько | 565 | **129** | 29% | **108.00** | 05/01/2022 |
| 5 | Тандэм Инвест ББСБ | 972 | **961** | 99% | **0.85** | 12/31/2022 |
| 6 | Бодь Даатгал | 2,340 | **1,177** | 50% | **5.00** | 06/30/2022 |
| 7 | Дархан Нэхий | 3,641 | **300** | 8% | **0.27** | 12/31/2022 |
| 8 | Материал Импекс | 5,153 | **315** | 6% | **230** | 04/30/2022 |
| 9 | Гутал | 2,248 | **2,248** | 100% | **1,427** | 05/04/2022 |
| 10 | Талх Чихэр | 5,140 | **256** | 5% | **250** | 10/01/2022 |
| 11 | АПУ | | | | **60** | 12/31/2022 |
| 12 | Би Ди Сек | 296 | **3** | 1% | **50** | 06/30/2022 |
| 13 | Улаанбаатар Хивс | 733 | **486** | 66% | **1,200** | 03/10/2022 |
| 14 | Монос Хүнс | 2030 | **818** | 40% | **2** | 09/01/2022 |
| 15 | Мах Импекс | 1,369 | **380** | 28% | **100** | 10/01/2022 |
| 16 | Ард Даатгал | 7,124 | **1,000** | 15% | **40** | 07/30/2022 |
| 17 | Ард Кредит | 4,193 | **1,260** | 30% | **4,5** | 07/01/2022 |
| 18 | Сүү | 9,401 | **1,589** | 17% | **4.62** | 05/01/2022 |
| 19 | Барилга Корпораци | | | | **500** | 04/14/2022 |
| 20 | Гермес Центр | 938 | **499** | 53% | **6,36** | 03/15/2022 |
| 21 | Мандал Даатгал | 5607 | **1,873** | 33% | **3** | 12/31/2022 |
| 22 | Ард Санхүүгийн Нэгдэл | 1,334 | **1,333** | 99% | **46.58** | 06/22/2022 |
| 23 | Монгол Базальт | 1,929 | **964** | 50% | **17.09** | 12/30/2022 |
| 24 | Таван Толгой | 15,065 | **13,535** | 89.8% | **257** | 10/01/2022 |
| 25 | Инвескор ББСБ | | **1,793** | | **25** | 06/30/2022 |
| 26 | Монгол Шуудан | 400 | **200** | 50% | **2** | 05/01/2022 |
| 27 | Мон-Ит Булигаар | | | | **600** | 07/01/2022 |
| 28 | Ариг Гал | 554 | **135** | 24% | **39.9** | 06/30/2022 |
| 29 | Ган Хийц | 4 | **24** | 100% | **100** | 07/01/2022 |
| 31 | Техник Импорт | 4,329 | **723** | 16.7% | **500** | 03/10/2022 |
| 32 | Хүрд | 4,095 | **227** | 7% | **1,677** | 03/15/2022 |
| 33 | Эрдэнэт Суврага | 21 | **780** | 100% | **5** | 06/30/2022 |

*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Компаниудын албан ёсны вэбсайт*

## Бэлтгэсэн:



**Р.Дарханбаяр**
Хөрөнгө оруулалтын шинжээч

Darkhanbayar@golomtcapital.com
+976 9490 4321

Golomt Capital®